

АГУУЛГА

Нэг. Ерөнхий тойм

Байгууллагын үндсэн үйл ажиллагаа

- 1.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хийсэн ажил
- 1.2 Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.3 Удирдлага, зохион байгуулалтын хийж хүрээнд хийсэн ажил
- 1.4 Хүний нөөцийн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.5 Сургалтын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.6 Санхүү төлөвлөлт, аж ахуйн ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.7 Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн ажлын

хүрээнд

- 1.8 Мэдээллийн технологийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил
- 1.9 Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Хоёр. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

- 2.1 Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.2 Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.3 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.4 Улсын бүртгэлийн хяналт шалгалтын ажлын хүрээнд хийсэн ажил
- 2.5 Улсын бүртгэлийн архивын ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил
- 2.6 Бичиг баримтжуулах ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд

хийж хэрэгжүүлсэн ажил

Дөрөв. Ковид-19 цар тахлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Тав. Зохион байгуулсан бусад ажил

Зургаа. Сайн үйлсийн аяны хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

Долоо. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Найм. Санал /Тулгамдаж буй асуудал/

НИЙСЛЭЛ ДЭХ УЛСЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ

Нийслэл дэх улсын бүртгэлийн газар нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрөөс явуулж буй бүртгэлийн талаарх бодлого чиглэл, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон тус газраас 2021 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хуульд заасан улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх гэсэн 2 үндсэн чиг үүргийн хүрээнд Газрын дарга, Захиргаа удирдлагын хэлтэс /11/, Харилцагчийн үйлчилгээний хэлтэс /4/, Архивын хэлтэс /9/, Дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтэс /385/ гэсэн нэгжүүдтэйгээр нийт 410 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын 1.499.140 /нэг сая дөрвөн зуун ерэн есөн мянга нэг зуун дөч/ гаруй оршин суугчдад төрөөс явуулж буй улсын бүртгэлийн талаарх бодлого шийдвэрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, өөрийн харьяа 187 нэгжээс Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тус газар нь “Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.2.2 хэсгийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

Энэ онд Засгийн газрын 3 тогтоолын 11 заалт, нийт 3 шийдвэрийн 11 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллалаа. Эдгээрээс тайлант хугацааны зорилтод бүрэн хэрэгжсэн 11 байгаа бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна.

УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар төрийн захиргааны байгууллага, агентлагийн дарга нарт үүрэг болгосон заалт бүрийг хяналтад авч, хяналтын хуудас хөтлөн ажиллаж байна. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд улирал тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, газар хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлт болгон ашиглаж байна.

Тайлангийн хугацаанд Засгийн газрын тогтоол 5, **Улсын бүртгэлийн ерөнхий газраас:** үйл ажиллагаатай холбоотой 12 тушаал, хүний нөөцтэй холбоотой 164 тушаал, 4 үүрэг, 17 чиглэл зөвлөмж, **Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас:** Нийслэлийн Засаг даргын 8 захирамж, 1 тогтоол, 19 чиглэл, Нийслэлийн онцгой комиссоос 1 тогтоол, 4 хурлын тэмдэглэл, 1 тушаал, 43 үүрэг чиглэл, 5 заавар зөвлөмж тус тус ирснийг хяналтанд авч, хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.

Хууль, дүрэм, журам, төлөвлөгөөний төсөлд санал өгөх талаар

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн бусад байгууллагаас санал авахаар ирүүлсэн дараах хууль, дүрэм, журмын төсөлд санал өгч ажиллав. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ;
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найрууллагын төсөл;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал;
- Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспортын бэлдэцэд бичилт хийх үйлдвэрийн үйл ажиллагааг зохицуулах журмын төсөл;
- “Улсын бүртгэлийн байгууллагын 2019-2021 онд хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”;
- “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”;
- Улсын бүртгэлийн байгууллагын “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын “НЭГ ИРГЭН-НЭГ БҮРТГЭЛ” хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл;
- Итгэмжлэгдсэн ажилтантай байгуулах ажил гүйцэтгэх гэрээний төсөл;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах УИХ-ын гишүүний нөхөн сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл;
- “Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын төсөл;

- Улсын бүртгэлийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал;
- Нийслэлийг хөгжүүлэх 2022 оны жилийн төлөвлөгөөний санал;
- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх зураг төсвийн төсөл;
- “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт”-ын санал;
- Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөр;
- Нийслэлийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө;
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахалтай тэмцэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, эдийн засгийг идэвхжүүлэх цогц арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөл;
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын төсөл
- “Төрийн албан хаагчийн ёс зүйн, сахилгын тухай” хуулийн төсөл;
- “Цар тахлын дараах эдийн засгийг дэмжих тухай” хуулийн төсөл зэрэг 22 хууль, дүрэм, журмын төслийг тус тус албан хаагчдад танилцуулж, саналыг холбогдох газруудад хүргүүлсэн байна.

1.2 Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах, иргэдийн төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чанар хүртээмжтэй авах нөхцлийг бүрдүүлэх дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. “Хотын засаглалыг сайжруулах төсөл, Азийн хөгжлийн сангийн санхүүжилтээр иргэдийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийг чирэгдэлгүй төлөх боломжоор хангаж алслагдсан хороодод цахим төлбөрийн хэрэгсэл болох пос машиныг байрлуулан ажилласан. Тайлант хугацаанд гэрэгэ насыг Хан-Уул дүүргийн 1,3,7,9,12 хороо, Баянгол дүүргийн 5,8,12,17 хороо, Баянзүрх дүүргийн 1-28 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 1,5,10,12 хороо, Сонгинохайрхан дүүргийн 1,7,11,20,42 хороо, Чингэлтэй дүүргийн 7,12,16,17,19 хороо, Багахангай дүүргийн 1 хороо, Налайх дүүргийн 7-р хороо, нийт 53 хороонд шинээр байрлуулсан. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар Гэрэгэ киоскоор 98745 иргэн, төрийн төлбөр тооцооны И-баримт аппликейшнээр- 54, нийт 198799 иргэн үйлчилгээ авсан.
2. Шинээр байгуулагдсан Сонгинохайрхан дүүргийн 11 /32-43/ хороо, Налайх дүүргийн 8-р хороо, хотоос алслагдсан хороо болох Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Баянзүрх, Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст 4G төхөөрөмжийг суурилуулсан. Уг төхөөрөмжийг суурилуулснаар шилэн кабель холбогдох боломжгүй, улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээ орох боломжгүй байсан хороодыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээтэй болгож иргэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөл хангагдсан.
3. Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Солонгосын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-ын хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд нийслэлийн бүх хороодын тоног төхөөрөмжийг шинэчилснээр бүх хорооноос буюу Нийслэлийн 171 хорооноос иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар хороодоос

иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээ авсан **29629** иргэн байна. Уг үйлчилгээг 2020 онд 31 хороогоор үзүүлдэг байсан бол 5,5 дахин нэмэгдэж бүх хороогоор үзүүлдэг болсон. Ингэснээр анхан шатны нэгжээс үзүүлэх бүртгэлийн нэр төрлийг нэмэгдүүлж, иргэний улсын бүртгэлийн анхдагч бүртгэлүүд болох иргэний шинэчилсэн бүртгэл, гэрлэлтийн бүртгэл, гэр бүл цуцлалтын бүртгэл, бүх төрлийн архивын лавлагаа, шинэ эцэг тогтоолтын бүртгэлийн үйлчилгээг бүх дүүргийн хороодоос үзүүлдэг боллоо. Зарим дүүргүүдэд ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл, үрчлэлтийн бүртгэлүүдийг мөн хорооноос үзүүлж эхлээд байна. Цаашид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон үндэсний энгийн гадаад паспорт олголтын бүртгэлийг хороонд шилжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар “Үндэсний энгийн гадаад паспортыг анхан шатны нэгжид байршуулах бизнес процессын зураглал хийх” ажлын хэсэг байгуулагдаж, бизнес процессын зураглалыг хийж, танилцуулахад бэлэн болсон. Уг үйлчилгээг туршилтаар анхан шатанд нэвтрүүлэх төвийн 6 дүүргийн 20 хороог сонгон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн сангийн “Хотын Засаглалыг сайжруулах төсөл”-д хүргүүлсэн.

1.3 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллав.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөл, шуурхай хуралдаан, холбогдох ажлын хэсгүүд, мөн Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаан, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тухай бүр оролцож өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын удирдах албан хаагчдын шуурхай хуралдааныг 24 удаа цахимаар зохион байгуулж, хурлаас нийт 141 үүрэг даалгавар өгч, биелэлтийг гарган ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон бусад дээд газарт дараах тайлан, мэдээ, судалгааг хүргүүлэх чиглэлээр:

Тус газар нь 2021 онд нийт 44 төрлийн тайлан, мэдээг давхардсан тоогоор **564** удаа холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт -1 удаа
2. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт-1 удаа
3. Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт-1 удаа
4. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгсөн үүрэг, даалгавар-тухай бүр болон 1,2,3 дугаар улирлын байдлаар гарган хүргүүлсэн-6 удаа
5. Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаварын биелэлт, чиглэлийн хэрэгжилт-39 удаа
6. Улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа бусад арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт-2 удаа
7. УБЕГ-т өдөр бүр хүргүүлдэг мэдээ-320 удаа

8. Газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт-2 удаа
9. НИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилтийн тайлан-1 удаа
10. Байгууллагын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг УБЕГ болон НЗД-т-4 удаа
11. НУБГ-ын 2020 оны санхүүгийн тайлан-1 удаа
12. НУБГ-ын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан-1 удаа
13. НУБГ-ын Нийгмийн даатгалын тайлан-11 удаа
14. НУБГ-ын Хүн амын орлогын албан татварын тайлан -4 удаа
15. НУБГ-ын орлогын тайлан-11 удаа
16. Үнэт цаасны бар кодын тайлан-11 удаа
17. Төсвийн гүйцэтгэл-11 удаа
18. Иргэний улсын бүртгэлийн сарын тоон мэдээ-11 удаа
19. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн тайлан-сар бүрийн 5-ны дотор
20. Нийслэлийн Засаг даргын албан даалгаварын хэрэгжилтийн тайлан-сар бүрийн 05-ны дотор
21. Нийслэлийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт-2 удаа
22. Байгууллагуудын сарын үйл ажиллагааны тайлан, мэдээ-11 удаа
23. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт -2 удаа
24. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар зохион байгуулах ажлын төлөвлөөний хэрэгжилт-2
25. Сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний хэрэгжилт-2 удаа
26. Үйл ажиллагааг үнэлэх үлгэрчилсэн загвар /НЗД-ын 335 дугаар захирамж/-ын биелэлт-1
27. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайлан-4 удаа
28. “Жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аяны тайлан-1 удаа
29. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн тайлан-2 удаа
30. “Дэм дэмэндээ” аяны тайлан-1 удаа
31. Сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан-1 удаа
32. Бичиг баримтын аян зохион байгуулсан тайлан-1 удаа
33. Нийслэлийн Засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчийн 100 хоногт хийсэн ажлын тайлан-1 удаа
34. Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлогын хүрээнд архи согтууруулах ундааны хор хөнөөлийг олон нийтэд таниулах аяны хэрэгжилтийн тайлан-1 удаа
35. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээ-4
36. Газрын 7 хоногийн ажлын мэдээ-32 удаа
37. Газрын 14 хоногт хийсэн ажлын товч тайлан-6 удаа
38. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан-сар бүр /11/ болон улирлаар /3/- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газарт-14 удаа
39. Нийслэлийн төрийн албаны зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тоон мэдээ-2 удаа
40. Архивын ажлын мэдээ сар бүр -11 удаа
41. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд шилжилт хөдөлгөөний мэдээ -2 удаа

42. Нууцын тайлан-2 удаа
43. “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө”-ний биелэлтийг 2 удаа
44. Дархлаажуулалтанд хамрагдсан албан хаагчдын өдөр тутмын мэдээг, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Онцгой Комисст 15 удаа тус тус хүргүүлэн ажилласан байна.

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын даргын 90 тушаал, шийдвэр, 3 гэрээний төслийг боловсруулж, батлав.

Мөн дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдэд 6 удаагийн чиглэл, 3 зөвлөмж, 4 үүрэг боловсруулан хүргүүлсэн.

Бусад байгууллагатай хамтран ажиллав.

Тус газар нь 2021 онд өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн халамжийн газар, Нийгмийн даатгалын газар, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Гэр бүл хүүхэд залуучуудын газар”, “Хотын засаглалыг сайжруулах” төсөл, бүх шатны ерөнхий боловсролын сургуулиуд, хууль хяналтын болон холбогдох төрийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Мөн өөрийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК, “Улаанбаатар Буян” ХХК “ Азийн хөгжлийн сан” “Монгол Шуудан” ХХК, “Дэлхийн Зөн” олон улсын байгууллага, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, “Голомт банк”, “Богд банк”, “Хаан банк” зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан.

Уг хамтын ажиллагааны хүрээнд тус газар нь 2015 оны 10 дугаар сараас MW холдинг ХХК-ний байранд түрээс төлөн үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газарт санал тавьсны үндсэн дээр 2021 оны 3 дугаар сараас Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо, Денверийн гудамж, голден вилл хотхон Монгол банкны D корпуст нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. Ингэснээр ажлын нөхцөл сайжирч түрээсийн төлбөрөө 40 орчим хувиар хэмнэсэн.

“Гэрэгэ системс” ХХК-тай хамтран 24 хороонд пос машин байрлуулсан.

“Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулан эрх зүйн актуудын эмхэтгэл бүхий гарын авлагыг Азийн сангийн санхүүжилтээр 500 ширхэгийг хэвлүүлэн албан хаагчдад өгсөн.

“Хотын засаглалыг сайжруулах” төслийн хүрээнд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан баррель үсэг бүхий гарын авлагын эхийг бэлтгэн хэвлэлтийн шатанд байна.

Улсын бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын хадгалалт, хамгаалалт, нөхцөлийг сайжруулах болон шаардлагатай байгаа өрөө тасалгааны судалгааг гарган дүүргийн Засаг даргын Тамгын газруудад хүргүүлэн ажилласан. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай дараах байдлаар хамтран ажилласан байна. Үүнд:

Багануур дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь 15м² талбай бүхий архивын 1 өрөөг шийдвэрлүүлж, архивын сан хөмрөгийг аюулгүй хадгалах боломжийг бүрдүүлсэн.

Багахангай дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран хэлтсийн үйлчилгээний танхим, архивын өрөө, хэлтсийн даргын өрөө танхимыг иж бүрэн засварлуулж, иргэд үйлчлүүлэх болон албан хаагчид ажиллахад ая тухтай байдлаар тохижуулан ажилласан.
2. Нийслэл хот байгуулагдсаны 382 жил, Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 81 жилийн ойг тохиолдуулан дүүргийн Засаг даргын дэмжлэгээр “Иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэм баримтлан амжилттай зохион байгуулсан. Уг арга хэмжээг зохион байгуулахад Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 878200 төгрөг шийдвэрлүүлэн ажилласан.

Баянгол дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Албан хаагчдын ажиллах нөхцөл орчныг сайжруулах зорилгоор 1 болон 2 дугаар давхарт иж бүрэн засвар хийж албан хаагчдын цайны өрөө гарган тохижуулсан. Дээрх өрөөнд ажилтан албан хаагч чөлөөт цагаараа амрах, өдрийн хоол идэх боломжийг бүрдүүлсэн.
2. Нэг цэгийн үйлчилгээний танхимын 10 цонхонд тус бүр нь 270,000 төгрөгийн үнэ бүхий шилэн хаалтыг дүүргийн Засаг даргын хөрөнгөөр шийдвэрлүүлж байрлуулсан.
3. Нэг цэгийн үйлчилгээний танхимын үүдэнд 8,000,000 төгрөгийн үнэ бүхий ариутгалын хаалгыг дүүргийн Засаг даргын хөрөнгөөр шийдвэрлүүлсэн.
4. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас албан хаагчдад халдвар хамгааллын хэрэгсэл /маск 1328ш, бээлий 1075ш, бээлий 918, халад 128ш, малгай 160, нүүрний хаалт 50ш цэнхэр спирт 20л/ шийдвэрлүүлж, албан хаагчдад олгосон.
5. Хороодын Засаг дарга нартай хамтран ажиллаж 7 хорооны улсын бүртгэгчийг ажлын өрөө тасалгаатай болгож, ажиллах нөхцлийг нь сайжруулсан.
6. Дүүргийн 2021-2024 оны төсөвт хэлтсийн тоног төхөөрөмж худалдан авахад зориулан 100,000,000 /Нэг зуун сая/ төгрөгийн суулгуулсан.
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхэд тулгардаг нийтлэг хүндрэлийг шийдвэрлэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Баянгол дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй анхны бүртгэлийн хэлтэс болох зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд тус хэлтсээс “Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Хөгжлийн ерөнхий газар” болон тус дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
 - Үйлчилгээний байрны үүдний хэсэгт тэргэнцэртэй иргэн орох налуу шатыг хийсэн.
 - Үйлчилгээний байрны гаднах зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэн автомашинаа байршуулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан.
 - Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний төрөл, бүрдүүлэх материалын жагсаалт зэргийг танилцуулсан видео танилцуулгыг бэлтгэж үйлчилгээний танхимд зориулалт бүхий дэлгэцээр нэвтрүүлж байна.
 - Монголын Үндэсний Телевизтэй хамтарч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээний төрлийг танилцуулах,

бүрдүүлэх баримтын талаарх дохионы хэлний тайлбар бүхий видео танилцуулгыг үйлчилгээний танхимд байршуулав.

- Сонсголын бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээний цонх нээж, төрийн албан хаагчийг дохионы хэлний сургалтанд хамруулсан.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэргэнцэргүй ирсэн тохиолдолд үйлчлэх тэргэнцэрийг дүүргийн Халамж үйлчилгээний хэлтэстэй хамтарч шийдвэрлэсэн.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн дугаар харгалзахгүй үйлчлэх тэмдэглэгээг үйлчилгээний цонх болгонд байршуулав.
- Тэргэнцэртэй иргэн үйлчлүүлэх тэгш хэмийн үйлчилгээний цонх, шилэн хаалтыг хийж байршуулав.

Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулах, төрийн үйлчилгээг тэгш хүртээх, архивын багтаамж хүрэлцэхгүй байгаа, албан хаагчдын ажиллах орчинг сайжруулах, үйлчилгээний танхимыг стандартын дагуу шийдэх зэрэг асуудлууд тулгамдаж буйг Баянзүрх дүүргийн Засаг даргад танилцуулж хэлтсийн шинэ байр барих газрын асуудлыг шийдвэрлэхээр болсон.
2. Тус дүүргийн хороодын бүртгэгч нарт 30 сая төгрөгийн үнэ бүхий "Гэрэгэ" пос машиныг Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газраас зардлыг шийдвэрлүүлж хорин найман хорооны улсын бүртгэгчид хүлээлгэн өгсөн.
3. Хороодын шилэн кабелийг сүлжээнд холбох ажлыг дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүжилтээр холбуулж WI-FI төхөөрөмжийг шийдвэрлүүлсэн.
4. Хорооны улсын бүртгэгч нарын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор хорооны Засаг дарга нартай хамтран үйлчилгээний зааланд ажиллаж байсан 17 улсын бүртгэгчийг тусдаа өрөөнд оруулж иргэдэд үйлчлэх нөхцлийг сайжруулсан ба үүний үр дүнд хувь хүний нууцыг хамгаалах нөхцөл боломжийг дээшлүүлсэн.

Налайх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Газрын албанд хүсэлт хүргүүлж, 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хэлтсийн байр барих газрыг тусгуулан шийдвэрлүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-2207004862 дугаартай гэрчилгээ авсан.
2. Дүүргийн Засаг дарга болон Газрын албанд хүсэлт гаргаж, хэлтсийн 16 албан хаагчид зуслангийн газар шийдвэрлүүлж, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.
3. Хэлтсийн коридорын шалыг солиулсан.
4. Дүүргийн онцгой комиссын шуурхай штабаас албан хаагчдад 500 ширхэг амны хаалт авсан.

Сонгинохайрхан дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Иргэдэд түргэн шуурхай хүртээмжтэй үйлчлэх ажлын хүрээнд дүүргийн нутгийн захиргааны байрны 1,2 дугаар давхрын 840 мкв талбайд бүртгэлийн үйлчилгээг үзүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
2. Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Хороодын Засаг дарга нартай хамтарч 18 хорооны улсын бүртгэгчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх өрөө тасалгаатай болгосон.

3. Дүүргийн Засаг дарга болон холбогдох газар хэлтэстэй хамтарч Гэрэгэ киоск машиныг нийт 43 хороонд байршуулахаар төлөвлөсөн. Үүнээс одоогийн байдлаар 3 хороонд Гэрэгэ киоск машиныг байршуулан ажиллаж байна.

Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 6 иж бүрэн компьютерыг хүлээн авч 1,5,8,10,11,12 дугаар хорооны улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн. Уг ажлын хүрээнд дээрх хороон дээр Иргэний шинэчилсэн бүртгэл болон бусад бүртгэлүүдийг хийх нөхцөлийг бүрдүүлж ажилласан.
2. Архивт өөр дээрээ бичилт хийж хадгалагдах хяналтын камер 2 ширхэгийг Дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран байршуулсан.

Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 1 ширхэг иж бүрэн компьютер шийдвэрлүүлсэн.
2. Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулж “Нэг цонхны үйлчилгээний танхим”-д 25 сая төгрөгийн засвар тохижилтын ажлыг хийж, ширээ сандлыг шинэчилсэн.
3. Тус хэлтэст хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг дүүргээс үзүүлэх болсонтой холбогдуулан нэг цэгийн үйлчилгээний танхимын тоог нэмэгдүүлж иргэний улсын бүртгэлийн тасгийн албан хаагчид Засаг даргын Тамгын газрын хуучин байранд 3 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийж тохижуулсан. Мөн албан хаагчдын амрах 1 өрөөг шийдвэрлүүлсэн.
4. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад “Дүүргийн 21 хороонд улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөр төлөх пос машин, бусад техник хэрэгсэл нийлүүлэх төсөл” бичиж хүргүүллээ. Төслийн хүрээнд 84 сая төгрөгийг 2022 оны дүүргийн төсөвт тусгуулсан.

Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс нь:

1. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас албан хаагчдын дархлааг дэмжиж бүтээгдэхүүн (нэг сая гурван зуун мянган төгрөгийн үнэтэй) шийдвэрлүүлсэн. Мөн албан хаагч нарт амны хаалт-1000 ширхэг, халат-20 ширхэг зэргийг шийдүүлсэн байна.
2. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газарт хороодод пос машин шийдвэрлүүлэх хүсэлт хүргүүлсний дүнд нэмж 10 пос машиныг энэ ондоо багтаан авахаар ажиллаж байна.
3. Тус дүүрэгт “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв” байдаггүй тул дүүргийн удирдлагуудад санал хүргүүлсний үр дүнд Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороонд байрлах “Бизнес инкубатор төв”-ийн байрыг төрийн үйлчилгээний нэгдсэн төв болгохоор засварын ажил хийгдэж байна.
4. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгээр тус хэлтсийн нэг цонхны үйлчилгээний байрыг иж бүрэн тохижуулах 300,000,000 төгрөгийн төсвийг батлуулан ажилласан.
5. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран хороодын улсын бүртгэгчдэд албан хэрэгцээнд нь зориулж эх нотлох баримт бичгийг хадгалах, зөөвөрлөх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилгоор нууцлал бүхий цүнхийг шийдвэрлүүлсэн.

1.4. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг

мөрдлөг болгон албан хаагчийг томилох, тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

2020 оны **348** ХАСХОМ шинэчлэн гаргасан, шинээр томилогдсон **89**, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн **8** албан хаагчийн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд бүртгэн, хүлээн авсан.

Мэдүүлэхээс татгалзсан болон хуулийн хугацаанаас хожимдуулж мэдүүлсэн албан хаагч байхгүй.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр томилогдсон **62** албан хаагчаас “Нууцын баталгаа”-г гаргуулан авсан. Мөн Ерөнхийлөгчийн сонгуулиар ажиллах Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн саналын дагуу **677** итгэмжлэгдсэн ажилтан томилох тухай тушаалыг гаргаж, нууцын баталгаа гаргуулсан. Нийт **739** албан хаагчаас “Нууцын баталгаа” гаргуулсан.

Газрын албан хаагчдын ажлын үнэмлэхийг шинээр хэвлэх, болон сунгах ажлыг хийж байна. Газрын 240 гаруй албан хаагчийн ажлын үнэмлэхийг шинээр хэвлүүлэх ажлыг зохион байгуулж, албан хаагчдад хүлээлгэн өгч ажилласан.



"Нэг хаалга-Нэг шинжилгээ" арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд тус шинжилгээнд хамрагдсан нийт **323** албан хаагчдын одоо амьдарч байгаа хаягийн мэдээлэл болон хамт амьдарч буй гэр бүлийн гишүүдийн мэдээллийг UB ERP системд бүртгэж, байршууллаа.

“Хүний нөөцийн удирдлага, хяналтын нэгдсэн систем”-д төрийн захиргааны бүх албан хаагчийн мэдээллийг шинэчлэн бүртгэж, баталгаажуулсан.

Ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор “Гэрэгэ системс” ХХК-тай хамтран албан хаагчдын ажилдаа ирсэн явсан цагийг QR код ашиглан бүртгэх ажлыг эхлүүлсэн. Уг ажлын хүрээнд нийт албан хаагчдыг системд бүртгэсэн.

1.5. СУРГАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан “Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын сургалтын төлөвлөгөө”-г баталж, **120** удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор **4104** ажилтан, албан хаагч хамруулсан. Үүнд:

- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газраас-25 удаагийн сургалтаар-722
- ❖ Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас-26 удаагийн сургалтаар-1013
- ❖ Дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүд – 44 удаагийн сургалтаар-2010
- ❖ Бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан-25 удаагийн сургалтанд -359

2020 оны мөн үетэй харьцуулбал зохион байгуулсан сургалтын тоо 98-иар буюу 2 дахин өсч, сургалт явуулах арга хэлбэрийг улам боловсронгуй болгож нийт сургалтын 78.7 хувийг цахимаар зохион байгуулсан байна.

Иргэдэд зориулсан эрх зүйн сургалтын хүрээнд: Иргэд, харилцагчдад зориулсан 33 удаагийн сургалтаар 2586 харилцагчид хамрагдсан байна.

1.6 САНХҮҮ, АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Газрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Олон улсын стандартад нийцүүлэн батлагдсан маягт зааврын дагуу хөтлөх, газрын болон дүүргүүд дэх улсын бүртгэлийн хэлтсийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллаж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- ❖ Байгууллагын 1,2, 3-р улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.
- ❖ Нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг тус тус хугацаанд нь хүргүүлсэн.
- ❖ Санхүүгийн тайлангийн аудитыг Их наяд аудит ХХК-аар хийлгэж, “ЗӨРЧИЛГҮЙ” дүгнэлт авсан.
- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг цаг хугацаанд нь хоцрогдолгүй оруулсан.
- ❖ Улсын бүртгэлийн ерөнхий газрын тайлан, мэдээ гаргах журмын дагуу сар бүр тайланг дараа сарын 2-ны дотор хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.
- ❖ Ирэх оны төсвийн төсөлд санал хүргүүлсэн.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасалдалгүй ханган ажиллах хүрээнд:

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр бүтээлтэй зарцуулах, хуваарилах, төлөвлөх ажлыг хийж гүйцэтгэсний үр дүнд төсөв /5899,5/ хэтрээгүй, төсвийн хуваарьт 4 удаа өөрчлөлт оруулж өр авлагагүй, төсөв нэмэгдүүлэх санал 3 удаа өгснөөр нүүлгэлтийн зардалд 70,0 сая төгрөг шийдвэрлүүлж ажлыг гүйцэтгэсэн. Мөн цалингийн санг 160,7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Урсгал засварын зардал, бичиг хэрэг хангамжийн хүрэлцээгүй зардлын 6,9 сая төгрөгийг Улсын бүртгэлийн ерөнхий газраар шийдвэрлүүлсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газраас 503 ширхэг 320,1 сая төгрөгийн өртөгтэй 162,2 сая төгрөгийн элэгдэлтэй компьютер, канон, принтер, тавилга, эд хогшил хүлээн авсан. Багануур дүүргийн Засаг даргын хөрөнгө оруулалтаар 19,6 сая төгрөгийн үнэтэй Приус-30 маркийн авто машин шийдвэрлүүлсэн. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар 5,4 сая төгрөгийн 2 ш компьютер, 2 ш принтер шийдвэрлүүлсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газраас Койка олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар 6 нэр төрлийн 827 ширхэг 2,0 тэрбум төгрөгийн өртөгтэй компьютер техник хэрэгсэл, 2 ширхэг авто машин хүлээн авсан.

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг тогтмол төвлөрүүлсэн.

2021 оны эхний 11 сарын байдлаар дараах орлогыг төвлөрүүлэн ажилласан байна.

	Хугацаа	Орлого, зардлын зүйл анги	Үйлчилгээний төрөл	Мөнгөн дүн /өссөн дүнгээр/
1	2021 оны 11 дүгээр сарын байдлаар	Улсын төсөвт	Үйлчилгээний орлого	8,7 тэрбум
2		Орон нутгийн төсөв	Торгууль шийтгэврийн орлого	577,6 сая

			Тэмдэгтийн хураамж	1,4 тэрбум
			Үл хөдлөх хөрөнгийн татвар	48,8 тэрбум

Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ нөхөн сонгуулийн санхүүжилтийг батлагдсан зардлын ангиллын дагуу зарцуулах ажлын хүрээнд:

- ❖ Ерөнхийлөгчийн сонгуулийн 499,2 сая төгрөгийн зардлыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан А/176 дугаар тушаалын дагуу зарцуулж тайлагнасан.
- ❖ Батлагдсан төсвийн хүрээнд сар улирлын хуваарь гарган ажилласан.
- ❖ Сар улирлын үйл ажиллагаатай холбоотой тоо мэдээг үнэ зөв гаргаж тайлагнасан. Төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүр гаргаж хэтрэлт гаргаагүй ажилласан бөгөөд зарим хэмнэлттэй зардлуудаас дутагдаж байгаа зардалд шилжүүлэн тухай бүрт нь арга хэмжээ авч ажилласан.

2021 онд 253047 ширхэг үнэт цаас Өмч хамгаалах зөвлөлөөр актлах шийдвэр гаргаж данснаас хассан. Үүнээс ажилтны алдаа 2945 ширхэг, техникийн алдаа 2761 ширхэг гарсан байна. Мөн дээд газрын шийдвэрээр 247341 ширхэг үнэт цаасыг акталсан. Алдаа гаргасан ажилтнуудаар 827028.32 төгрөгийн төлбөрийг бүрэн төлүүлсэн.

2021 онд 7 нэр төрлийн 106 ширхэг 202,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 15 нэр төрлийн 253043 ширхэг 47,9 сая төгрөгийн үнэт цаасыг актлан ажилласан.

1.7 АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

1.7.1 Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Баримт бичгийн шийдвэрлэлт болон бусад мэдээллийн эрэлт хайлтыг шуурхай болгох үүднээс газарт ирсэн баримт бичгийг “Албан хэрэг хөтлөлтийн E-DOC програм”-д бүртгэн цахим санамжид оруулан ажиллалаа.


- ❖ Тайлангийн хугацаанд **7845** албан бичиг хүлээн авч edoc програмд бүртгэснээс хариутай бичиг **2918** байна. Дээрх албан бичгээс 6258 нь албан хэрэг хөтлөлтийн edoc систем хэрэглэгч байгууллагууд цахим хэлбэрээр ирсэн бол үлдсэн 1587 албан бичгийг байгууллага дээр скайнердаж цахимжуулсан байна. Мөн able програмд нийт 38 албан бичиг бүртгэгдэж шилжүүлэн шийдвэрлэсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд ирсэн бичгийн шийдвэрлэлт **96,37%**, шийдвэрлэлтийн дундаж хоног 11 хоног 25 цаг байна.
- ❖ Энэ онд нийт **69** тушаал /Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр-19, Хүний нөөцийн чиглэлээр-50 /, гаргаж edoc-т 923, able-т 12 албан бичгийн төслийг холбогдох ажилтнуудаас хүлээн авч, удирдлагаар баталгаажуулан хэвлэмэл хуудсанд буулган албажуулан, нэгдсэн дугаар олгож явуулсан. Эдгээрээс Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн програмаар илгээж бусад албан бичгүүдийг дугтуйлан хаяглаж, шуудангаар холбогдох газарт нь хүргүүлсэн.
- ❖ Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”

захирамжийн дагуу 2021 оны 5 сарын 24-ний өдрөөс И-ТОКЕН буюу тоон гарын үсгэнд бүрэн шилжсэн бөгөөд газар, хэлтсийн дарга нар тоон гарын үсэг ашиглаж нийт **69** албан бичиг холбогдох газруудад хүргүүлсэн байна.

- ❖ Газрын албан хэрэг хөтлөлтийн талаарх ирсэн, явсан бичгийн тайланг 7 хоног бүрээр, баримт бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, баримт бичгийн эргэлтийн мэдээг 14 хоног тутамд гарган ажилласан.

Байгууллагын архивын чиглэлээр:

- ❖ 2020 онд хөтлөгдсөн байнга хадгалах, 70 жил хадгалах, түр хадгалах хадгаламжийн нэгжийг батлагдсан хуваарийн дагуу холбогдох хэлтэс, нэгжүүдээс нийт **471** хадгаламжийн нэгж хүлээн авч, архивт нөхөн бүрдүүлэлт хийлээ.
- ❖ Архивт баримт шилжүүлэх үед хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийсэн.
- ❖ Хүлээн авсан хадгаламжийн нэгжид хадгалах хугацааны ангиллаар данс бүртгэл үйлдсэн.
- ❖ Архивын цэвэрлэгээ, үйлчилгээ хуваарийн дагуу тогтмол хийгдэж байна.
- ❖ Байгууллагын архивын чийг, дулааныг өдөр тутам тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтөлж байна.
- ❖ Албан хаагчдын албан хэрэгцээнд архивын баримт ашиглуулахдаа бүртгэлийг тогтмол хөтөлж байна.
- ❖ Хэвлэмэл хуудсны тайланг хүлээн авч, хүчингүй болсон хэвлэмэл хуудас байхгүй байна.
- ❖ Дотоод хэлтсийн ажилтнуудын гадуур ажиллах ажилтны бүртгэлийн дэвтрийг өдөр тутам хөтөлж байна.
- ❖ Байгууллагын архивт нягтаршуулсан шүүгээ 5 ширхэгийг шинээр авсан.



1.7.2 Өргөдөл, гомдол шийдвэрлэлт:

Тус газар нь иргэн, хуулийн этгээдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд хариу өгөх жишиг тогтоох үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

2021 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 285 өргөдөл, гомдол, хүсэлт, санал ирсэн байна.

1.7 Шийдвэрлэлтийн дундаж хугацаа

д/д	Нэгж	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Тоо
-----	------	-------------------------------	-----

1	Баянгол дүүрэг дэх УБХ	4 хоног 20 цаг 39 минут	22
2	Баянзүрх дүүрэг дэх УБХ	8 хоног 8 цаг 44 минут	76
3	Хан-Уул дүүрэг дэх УБХ	4 хоног 4 цаг 29 минут	47
4	Сонгинохайрхан дүүрэг дэх УБХ	4 хоног 4 цаг 53 минут	36
5	Сүхбаатар дүүрэг дэх УБХ	10 хоног 8 цаг 2 минут	59
6	Чингэлтэй дүүрэг дэх УБХ	10 хоног 20 цаг 8 минут	12
7	Налайх дүүрэг дэх УБХ	19 хоног 3 цаг 17 минут	1
8	Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар	8 хоног 5 цаг 25 минут	31
Нийт дундаж		9 хоног 12 цаг 29 минут	285

Авч хэрэгжүүлсэн сайжруулалтын арга хэмжээ:

“Өргөдөл, гомдолд нэр дурьдагдсан ажилтнуудад “Төрийн албан хаагчийн ёс зүй ба байгууллагын үйлчилгээний стандарт” сургалтыг 2 удаа зохион байгуулснаар 27 ажилтан хамрагдан тодорхой кейсүүд дээр дадлага ажил хийв. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нийслэлийн сургалт, судалгааны төвтэй хамтран 5 дугаар сарын 4-13-ны өдрүүдэд нэгжийн удирдах албан тушаалтан /ТЗ-7-оос дээш /- нуудад “Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албан хаагчийн гадаад төрх бүрдүүлэлт” сэдвээр 2 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 90 гаруй ажилтанг хамруулсан. Нийт 117 ажилтан хамрагдсан.

“ДАТА” бааз үүсгэж, холбогдох арга хэмжээг авах: “Өргөдөл, гомдлын агуулга, харьяалал болон холбогдох мэдээлэл бүхий “ДАТА” үүсгэж, шаардлагатай тохиолдолд хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээг авах санал хүргүүлсэн.

Мэдээллээр хангах: Газрын даргын шуурхай хуралдаанд тухайн сарын “Өргөдөл, гомдлын тайлан” болон иргэд, харилцагчдаас ирүүлсэн санал, хүсэлтийг танилцуулж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэн ажиллаж байна.

Байгууллагын албан ёсны цахим сайтад өргөдөл, гомдлын тайланг сар бүр тогтмол байршуулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажилласан.

Богиносгосон цагаар ажиллах цаг үеийн яаралтай гаргасан шийдвэрүүдийн иргэд, харилцагчдад шаардлагатай мэдээллийг ил тод, түргэн шуурхай мэдээлсэн.

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлтийг сайжруулах зорилгоор ажлын төлөвлөгөө боловсруулан, сайжруулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ERP.Ulaanbaatar.mn системд тус газрын дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдийг байгууллагын дотоод нэгжүүдэд шилжүүлэх хүсэлт хүргүүлсэн нь өргөдөл, гомдол санал хүсэлтийг шийдвэрлэх шат дамжлагыг бууруулах ач холбогдолтой байна.

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 12 цаг 29 минут байна. Энэ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас бага хугацаанд шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шийдвэрлэлтийн дундаж хугацаа 1 хоногоор богиносон шуурхай шийдвэрлэсэн байна.

1.8.МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Мэдээллийн сан, программ хангамжийн үйл ажиллагаа.

Газрын тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалтад хяналт тавих, мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

Тоног төхөөрөмж, програм болон сүлжээний аюулгүй байдлыг тасалдуулахгүй ажиллах хүрээнд тоног төхөөрөмжийн засвар гэмтлийг тухай бүр оношлон шуурхай засварлаж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Энэ онд хороодын бүртгэгч нар улсын бүртгэлийн нэгдсэн санд хандах боломжтой болж сүлжээнд холбогдсон. Шинээр байгуулагдсан Сонгинохайрхан дүүргийн 11 /32-43/ хороо, Налайх дүүргийн наймдугаар хороо, хотоос алслагдсан хороо болох Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, мөн Баянзүрх дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс, Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст 4G төхөөрөмжийг суурилуулсан. Уг төхөөрөмжийг суурьлуулснаар шилэн кабель холбогдох боломжгүй, улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээ орох боломжгүй байсан хороодыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээтэй болгож иргэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцлөөр хангагдсан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын <https://erp.ulaanbaatar.mn/>- системээр хүнийн нөөцийн удирдлага, утасны жагсаалт, цаг бүртгэл, мэдээ мэдээлэл, ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар, олон нийтийн сүлжээ, тайлан судалгаа, өргөдөл гомдол, үндсэн хөрөнгө бүртгэл, үйл явдал, судалгаа авах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөх, дотоод мессенжер гэх мэт маш өргөн боломжтой цогц системийг албан хаагч нарт хандах эрхийг тохируулсан.

1.9 БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ СУРТАЛЧИЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Байгууллагын ил тод нээлттэй, шуурхай хариуцлагатай байдлыг хангаж, төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилж мэдээлэх, иргэдийн санал бодлыг сонсох, “Нээлттэй хаалганы өдөр”, “Мэдээллийн цаг”, бүртгэлийн “Ёслолтой арга хэмжээ”, иргэдэд чиглэсэн бусад үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ил тод, нээлттэй, хариуцлагатай, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилтуудыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- ❖ Монгол Улсын Засгийн газрын 411 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай”, 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу байгууллагын эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл болон байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдсон мэдээ, мэдээллийг “Мэдээллийн самбар”, цахим дэлгэц, байгууллагын болон хэлтэс нэгжийн цахим хуудас, фэйсбүүк хуудсанд бүрэн байршуулж, мэдээллийг тухай бүрт шинэчлэн ойлгомжтой байдлаар байршуулсан.
- ❖ Байгууллагын хэмжээнд иргэдийг цагийн хуваарьгүйгээр хүлээн авч, санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. Газрын нийт албан хаагчид болон өргөдөл, гомдол хүлээн авах мэргэжилтний мэдээллийг газрын цахим хуудсанд нээлттэй байршуулан, Нийслэлийн нутгийн захиргааны

байгууллагуудын нэгдсэн төлөвлөлтийн систем /ERP/-д цахим өргөдөл, гомдлын дэд системийг ашиглан, Засгийн газрын 11-11 төв, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, Шуурхай удирдлага, зохицуулалтын төв, www.ub1200.mn цахим хуудас, smart UB, Clean UB аппликейшн, 1800-1200, бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 тусгай дугаарын утас, газрын 7777-1890 болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон тус газрын веб хуудас, хэлтэс нэгжүүдийн ажлын байр, иргэдээс санал хүсэлт авах хайрцаг, дэвтэр зэрэг эх сурвалжаар иргэд, байгууллагаас 285 хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэн ажилласан.

- ❖ Дүүргийн зарим чиг үүргийг хороодод үе шаттайгаар шилжүүлэх арга хэмжээний хүрээнд иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээ, иргэний үнэмлэх дахин олголт, төрсний бүртгэл, гэрлэлтийн бүртгэл, гэрлэлт цуцлалтын бүртгэл, бүх төрлийн лавлагаа зэрэг иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг шилжүүлснээр иргэдэд засаг захиргааны харьяалал харгалзахгүйгээр үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна. Ингэснээр:

- Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг зөвхөн 1 дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн 9 цэгээс авдаг байсан бол хороодод шилжүүлсэнээр нийт 171 цэгээс үзүүлж үйлчилгээний хүртээмж нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулсан.

Хоёр. Байгууллагын албан ёсны цахим хуудас болон нүүр номоор сурталчилсан байдал:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл болон хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг бүхий л арга хэлбэрээр шуурхай хүргэхийн зэрэгцээ бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд:

- ❖ Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.
- ❖ Нийслэл болон хэлтсүүдийн цахим хуудас, нүүр хуудсанд /FACEBOOK/ нийт 265 удаа шинэ мэдээ, мэдээлэл оруулж, нийлбэр дүнгээрээ **658136** харилцагч зочилж, улсын бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл шинээр авсан байна.
- ❖ Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлын хүрээнд MYOHT, ТВ-8, EAGLE, телевизээр 4 удаа, фм радиогоор 5 нийт 9 удаа мэдээлэл өгч ажилласан байна.
- ❖ Тус газрын 77771890 тусгай дугаарын утсаар төвийн хэлтсүүд-1596, дүүргийн хэлтсүүд 11880 нийт 13476 иргэн, хуулийн этгээдийг мэдээ, мэдээллээр ханган ажилласан.
- ❖ Энэ онд 242 хосын гэрлэсний бүртгэл, 353 шинээр төрсөн хүүхдийн гэрчилгээг ёслолтойгоор гардуулж, иргэний андгай өргөх ёслолд 334 хүүхдийг хамруулан ажилласан. Дээрх арга хэмжээнд нийт 929 иргэн оролцсон байна. Эдгээр арга хэмжээнүүдийг тухай бүр сурталчилан ажилласан.
- ❖ “Мэдээллийн самбар”-ыг байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг шинэчлэв. Мэдээллийн самбар”-ын агуулгыг үлгэрчилсэн байдлаар гаргаж, хэлтсүүдэд газрын даргын чиглэлээр хүргүүлэн ажилласан.

- ❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн хэлтэстэй хэрхэн хамтран ажиллах талаар санал хүргүүлсэн.

Гурав. Хүний нөөцийн ил тод байдал:

Энэ хүрээнд <https://www.niislel@burtgel.gov.mn> байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Байгууллагын бүтэц, орон тоог баталсан тушаал, баталсан орон тоонд ажиллаж байгаа албан хаагчдын мэдээлэл, албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаал, хүний нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.


Дөрөв. Төсөв санхүүгийн ил тод байдал:

Газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг байршуулан ажиллаж байна.

Тус байгууллагын шилэн дансанд <https://www.niislel@burtgel.gov.mn/> нийт 11 удаа 145 мэдээллийг байршуулсан.

Улсын бүртгэлийн байгууллагын “Үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд:

- ❖ Өнгөрсөн стандартын хэрэгжилт 88 хувь байсан бол 2021 оны дүнгээр 95 хувь буюу 7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс болон Нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийн стандартын хэрэгжилтийг дундчилан харахад 93 хувьтай байгаа нь өмнөх жилээс 5 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдэд “Байгууллагын үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, өдөр тутам хяналт тавих, тайлагнах зэрэг чиг үүргийг тухайн нэгжийн хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч нар хэрэгжүүлж, сар бүр НУБГ_СТ_1, НУБГ_СТ_2 маягтаар хэрэгжилтийг дүгнэж, газарт ирүүлж хэвшсэн.

Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Тус газраас харилцагчийн үйлчилгээний чиглэлээр хэлтсүүдэд 4 удаагийн чиглэл хүргүүлсэн.
- Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2021 оны 1 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд сарын ажлын хэсэг томилогдон төвийн 6 дүүрэг, 6 Нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын ажлын байрны нөхцөл байдал, “Коронавируст (Ковид-19) халдвараас сэргийлэх халдвар хамгааллын

дэглэм”, Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилттэй танилцаж, холбогдох зөвлөмж, зааврыг өглөө.

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг, даалгавар”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Газрын даргын баталсан “Байнгын ажлын хэсгийн” удирдамжийн дагуу ажлын хэсэг буюу хуваарийн дагуу жилийн хугацаанд 7 хоног бүрийн Мягмар гараг бүрт Баянгол, Баянзүрх, Хан-уул, Багануур, Багахангай, Сүхбаатар, Чингэлтэй, Налайх дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн нийт 128 хороод дахь улсын бүртгэгчийн ажлын байрны үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, харилцагчийн үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гадна дээрх хороодын Засаг дарга нарт Улсын бүртгэлийн эрх зүйн орчин ба байгууллагын үйлчилгээний стандартын тухай мэдээлэл өгч, улсын бүртгэгчийн ажлын байрны нөхцөл байдал болон сүлжээний аюулгүй байдлыг хэрхэн сайжруулах талаар санал солилцож дээрх Хороод дахь улсын бүртгэгчийн “Үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг “Дүгнэх хуудас”-аар дүгнэж ажиллаа.
- Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр Нийслэл дэх Улсын бүртгэлийн газарт шинээр томилогдсон төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй ба байгууллагын үйлчилгээний стандарт” сэдвээр 3 удаа зохион байгуулав. Сургалтад 2020 оны 4 дүгээр улирлаас 2021 оны 3 дугаар улиралын хугацаанд шинээр томилогдсон 50 албан хаагч, өргөдөл, гомдолд нэр дурьдагдсан ажилтан, албан хаагчдад зориулсан сургалтыг 2 удаа зохион байгуулж 52 албан хаагч нийт 5 удаагийн сургалтанд 102 албан хаагч хамрагдав.

Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс “Хандлага, ёс зүй, ур чадвар” хэрэглэгчдийн үнэлгээг байршуулан хэрэглэгчдийн үнэлгээг албан хаагчдад тухай бүр танилцуулж санал хүсэлтийг уламжлан үйл ажиллагаагаа сайжруулан ажилллаа.



ХОЁР.УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийслэлийн хэмжээнд 2021 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар **506611** иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг газар, 9 дүүрэг болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, хороодоор хүргэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Төрсний бүртгэл-32190
- ❖ Гэрлэлтийн бүртгэл-5897
- ❖ Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-1605
- ❖ Үрчлэлтийн бүртгэл-418
- ❖ Овог эцэг /эх/-ийн нэр,нэр өөрчлөлтийн бүртгэл-1279
- ❖ Эцэг тогтоолтын бүртгэл-906
- ❖ Нас баралтын бүртгэл-9754
- ❖ Засвар өөрчлөлт-403
- ❖ Гэрчилгээний дахин олголт-6443
- ❖ Аймаг хотоос бүрмөсөн шилжин ирсэн-21807
 - Насанд хүрэгч-15106
 - 16-аас доош насны-6701
- ❖ Хот доторх шилжилт хөдөлгөөн-92607

- Насанд хүрэгч-56577
- 16-аас доош насны-36030
- ❖ Нийт олгосон иргэний үнэмлэх-98968
 - Шинээр олгосон иргэний үнэмлэх-17609
 - Дахин олгосон иргэний үнэмлэх-36947
 - Иргэний үнэмлэх хугацаа дуусч авсан-44412
- ❖ Үндэсний энгийн гадаад паспорт олголт-64253
- ❖ Лавлагаа олголт-170081



Иргэний бүртгэлийн чиглэлээр үзүүлсэн үйлчилгээ 2020 оны мөн үетэй харьцуулахад 1,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй гадаадад зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотой үндэсний энгийн гадаад паспорт олголтын бүртгэл эрс багассантай холбоотой. Мөн сонгуультай холбоотойгоор шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зогсоосон нь үйлчилгээний тоо багасах шалтгаан болсон.

2.2 ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:

Нийслэлийн хэмжээнд 2021 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар **272502** эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- ❖ Анхны бүртгэл-30025
- ❖ Өмчлөх эрх шилжих гэрээ-50012
- ❖ Барьцааны гэрээ-167036
- ❖ Бусад гэрээ-1871
- ❖ Бүртгэлд өөрчлөлт оруулах-6978
- ❖ Лавлагаа, хуулбар-15717
- ❖ Тусгай болон урьдчилсан тэмдэглэлийн дүн-863




Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2020 оны мөн үетэй харьцуулахад 27,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2.3 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЧИГЛЭЛЭЭР:


Нийслэлийн хэмжээнд 2021 оны 11 дүгээр 25-ны байдлаар 19121 хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- ❖ Анхны бүртгэл – 4009
- ❖ Дахин авсан –1122
- ❖ Нэр олгох-3772
- ❖ Хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах-4388
- ❖ Хуулийн этгээдийн үйлчилгээ явуулах эрхийг сунгах-86
- ❖ Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой бусад бүртгэл-2906
- ❖ Лавлагаа-2838



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2021 онд иргэдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2020 оны бүртгэлээс 4 дахин /14852 бүртгэлээр/ өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 2021 оноос нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв болон дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдээс үзүүлдэг болсонтой холбоотой. Энэ нь үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах томоохон ажил болсон юм.

Дээрх 3 төрлийн улсын бүртгэлийн үйлчилгээний төрлөөр 2021 оны 11 дүгээр сарын байдлаар нийслэлийн хэмжээнд нийт 752958 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.




Тус газрын 2021 онд иргэд, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээ нь 2020 оны мөн үеийнхээс 2 хувиар өссөн байна.

2.4 БИЧИГ БАРИМТЖУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/487 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгмийн олон талт үйлчилгээнд хамруулах зорилгоор иргэдийн бичиг баримтын

зөрчлийг арилгах ажлын хүрээнд Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, ШШГЕГ-ын харъяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан хөдөлмөр хийлгэх газар, Улаан загалмайн нийгэмлэг, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, дүүргийн хөдөлмөр халамжийн газар, банк бус санхүүгийн байгууллага зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан.

Тайлангийн хугацаанд зорилтот бүлгийн болон бичиг баримтгүй 1979 иргэнийг бичиг баримтжуулан ажиллалаа.



Бичиг баримтын зөрчил арилгах аяны хүрээнд: “Иргэний бичиг баримтын зөрчил арилгах” 2 сарын аян зохион байгуулж, зөрчлийг арилгуулж хяналт тавьж ажилласан. Аяны хугацаанд дүүргүүдийн хороодын улсын бүртгэгч, хорооны Засаг дарга, ажлын хэсгийн ахлагч, хэсгийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэйгээр хорооны хүн амын судалгаанд тулгуурлан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сантай тулгалт хийж ажилласан ба Нийслэлийн 9 дүүргийн 171 хороодод бүртгэлтэй 1541471 иргэн хамрагдахаас 1376646 иргэд буюу 89 хувь нь хамрагдсан байна. Илэрсэн зөрчлүүдийг арилгуулах чиглэлээр Багануур 100 хувь, Багахангай 100 хувь, Баянгол 95 хувь, Баянзүрх 29 хувь, Налайх 24 хувь, Сонгинохайрхан 15 хувь, Сүхбаатар 69 хувь, Хан-Уул 98 хувь, Чингэлтэй 24 хувийн гүйцэтгэлтэй тус тус ажилласан. Аяны хугацаанд бүртгэлийн нийт 13833 иргэний зөрчлийг илрүүлснээс 7448 иргэний буюу 54 хувийн зөрчлийг тэр дор нь арилгуулсан байна.

2.5. УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Архивын хэлтэс нь төрөөс архивын үйл ажиллагааны талаар явуулж буй бодлого чиглэлийг нийслэлийн бүртгэлийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааны явцад бий болсон баримтыг архивт хүлээн авах, нөхөн бүрдүүлэлт хийх, эмхлэн цэгцлэх, нягтлан шалгах, журмын дагуу хадгалж хамгаалах, ашиглуулах, лавлагаа мэдээлэл, хуулбар олгох, данс, тоо бүртгэл хөтлөх, архивын ажлын хяналт шалгалт хийх, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдийн архивын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой авах арга хэмжээний тухай газрын даргын 2021 оны А/06 дугаар тушаалыг батлуулж, уг тушаалын хавсралтаар иргэний баримтын архивын сан хөмрөг, байгууллагын тоног төхөөрөмж нүүлгэн шилжүүлэх Ажлын хэсэг, архивын хадгаламжийн нэгжийг тоолох тооллогын Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, эд хогшлын тооллогын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж нүүлгэлтийн ажлыг энэ оны 3 дугаар сард зохион байгуулсан. Тус газрыг нийслэлийн Баянзүрх дүүрэг 1 хороо, Денверийн

гудамж, Монгол банкны “Д” байр буюу архивын эх нотлох баримт, сан хөмрөг байрлах стандарт, зориулалтын бус байранд нүүлгэхэд иргэний баримтын архивын 2184 хайрцаг архивын баримтыг 29 удаагийн тээвэрлэлтээр шилжүүлэн байрлуулсан.

Зураг 1.



Зориулалтын бус тавиурыг засч тохижуулан архивын баримтыг байрлуулах, хууль тогтоомжид заагдсан архивын сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын тамгын газарт танилцуулсны үр дүнд 120 ширхэг нягтруулсан шүүгээг шийдвэрлэн өгч, угсралт, суурилуулах ажлыг өөрсдийн хүчээр хийж газар дотор дахин баримтуудыг ангилан **111590** баримтыг өрж байрлуулсан.

Зураг 2.



- ❖ **Нөхөн бүрдүүлэлтийн чиглэлээр:** Нийт **130600** баримт иргэний баримтын архивт хүлээн авсан. Үүнээс 9 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс **111590** баримт, орон нутгийн бүртгэлийн хэлтсээс **19010**, эх нотлох баримт **493** хадгаламжийн нэгж, баримт архивт хүлээн авч, нягтлан шалган, ангилан төрөлжүүлсэн.
- ❖ Сан хөмрөгт байрлуулах **111590** баримтыг он цаг, нэрийн дараалалд оруулан галиглан цэгцэлсэн.
- ❖ Галиглаж цэгцэлсэн **111590** баримтыг хадгаламжийн санд байрлуулсан байна.

Иргэний баримтын цахимжуулалтын сангаас олгосон лавлагааг үндэслэн мэдээллийн санд **157** бүртгэлийг нөхөн оруулахаар иргэний улсын бүртгэлийн газарт албан бичгээр хүргүүлсэний үндсэн дээр дээрх иргэдийн бүртгэлийн зөрчлийг арилгуулан ажилласан.

Архивын баримтын ашиглалт: Нийт **168718** лавлагаа, мэдээлэл олгосон. Үүнээс хууль хяналтын болон төрийн байгууллагын хүсэлтээр **29581**, иргэнд **170081** лавлагаа, албан хэрэгцээнд **6780** мэдээлэл олгосон байна.

Иргэний хувийн хэргийн бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс нягтлан шалгах шаардлагатай **31050** баримтыг сүлжээнд шалгаж, холбогдох газарт хүргүүлэх, бусад сан хөмрөгт шилжүүлэн байрлуулах ажлуудыг хийсэн. Бүртгэлийн зөрчлийн арилгахад **108** баримтыг хуулбарлан холбогдох ажилтан, иргэнд олгосон.

Сан хөмрөг №1, 3-т тоо бүртгэлийг шинэчлэн хөтлөх зорилгоор хадгаламжийн нэгжид тооллогыг өөрсдийн хүчээр 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт **5699** ХН, **534253** хувийн хэрэг, **759018** хуудас баримтыг тоолоод нүүлгэлтийн ажлын хүрээнд Сан хөмрөг 1, 2, 3, 4-т хадгалагдаж байсан 34000 гаран хадгаламжийн нэгжийг 1249 хайрцагт савлан гар данс хөтлөн шинэ байранд 120 ширхэг нягтаршуулсан шүүгээ шинээр байрлуулж хувийн хэргийг задлан галиг үүсгэн байрлуулж байна.

Улсын бүртгэлийн архивын нэгдсэн цогцолбор байр ашиглалтанд орсонтой холбоотойгоор Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын даргын 2021 оны 10/6784 тоот албан бичиг, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын даргын баталсан “Нүүлгэн шилжүүлэлт хийх, тээвэрлэх явцад хяналт тавин ажиллах хуваарь”-ийн дагуу Сонгинохайрхан дүүргийн “Г” дугаарын 61599 ширхэг хувийн хэргийг 635 хайрцагаар багцлан 6 машинаар, Баянзүрх дүүргийн “Г” дугаарын 31450 ширхэг хувийн хэргийг 600 хайрцагаар багцлан 4 машинаар, Баянгол дүүргийн “Г” дугаарын 6876 ширхэг хувийн хэргийг 148 хайрцагаар багцлан 2 машинаар, Чингэлтэй дүүргийн “Г” дугаарын 19634 ширхэг хувийн хэргийг 408 хайрцагаар багцлан 3 машинаар, Хан-Уул дүүргийн “Г” дугаарын 14190 ширхэг хувийн хэргийг 193 хайрцагаар багцлан 2 машинаар, Сүхбаатар дүүргийн “Г” дугаарын 13254 ширхэг хувийн хэргийг 311 хайрцагаар багцлан 3 машинаар тээвэрлэж, нийт 147003 ширхэг дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн архивт байршуулсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт болох газрын “Г” дугаарын хувийн хэргийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын архив, үйлчилгээний цогцолбор төв рүү нүүлгэн шилжүүлэв.

Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газраас 2021 оны 10/7457 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/290 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журам”-ын 4.5.2-т заасны дагуу нийслэл дэх 6 дүүрэг, нэг цэгийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээс шинээр болон нэмэлт өөрчлөлтөөр хүлээн авсан хувийн хэрэг, эх нотлох баримт бичгийг зөөх чиглэл, хуваарийг гарган, баримт бичиг тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагааг ханган, хяналт тавин ажиллаж байна. Мөн бүртгэлийн хувийн хэрэг, баримт бичгийг холбогдох журмын дагуу хүлээлцэх, архивын санд байрлуулан ажиллах архивч нарын ажил үүргийн хуваарийг гарган, мөрдөн ажиллаж байгаа эсэхэд ахлах архивч, мэргэжилтэн нар хяналт тавьж, зөвлөн туслан ажиллаж байна.

2.5 Хяналт шалгалтын ажлын хүрээнд:

2021 онд төлөвлөгөөт шалгалт-31, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт-29, өргөдөл санал гомдлын мөрөөр хийсэн шалгалт-1972, гүйцэтгэлийн шалгалт 6 нийт **2026** бүртгэл хяналтын шалгалт хийж ажилласан.

Тайлангийн хугацаанд: /2021 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар/

- ❖ Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-59545
- ❖ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-10720
- ❖ Хуулийн этгээдийн чиглэлээр-4748

- ❖ Архивын чиглэлээр-894 нийт **78410** бүртгэлд байнгын хяналт тавьж, **7477** зөрчил илрүүлэн, хяналтын улсын байцаагчийн **3090** дүгнэлт гарч, **577.60** /таван зуун далан долоон сая зургаан зуун мянга/ төгрөгийн торгууль ногдуулсан байна.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

3.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн зохион байгуулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий Улсын бүртгэлийн ерөнхий газар /цаашид “УБЕГ” гэх/-ын даргын 2021 оны А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт тус газраас орж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө /6 бүлэг бүхий 94 арга хэмжээ бүхий/-г баталсан. 6-р сарын 10-ны байдлаар 75 арга хэмжээ буюу 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэний тоог хороо бүрээр 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар гарган дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хүргүүлсэн.

Сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэрийг зарласан сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хүлээн авч, нягтлан шалгаж, тогтоолд заасан сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрийн мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлд 2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр бүрэн тусгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах журам”-ын 2.5, 2.6-д заасны дагуу тухайн сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтад үнэн зөв, давхардал, зөрчилгүй тусгасан эсэхийг нягтлан шалгаж, сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, 4 дүгээр сарын 1-ний өдөр www.burtgel.gov.mn цахим хуудсанд байрлуулж, иргэдийг өөрийн болон байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн сонгогчийн мэдээлэлтэй танилцах боломжоор ханган ажилласан.

Цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалтыг 24 цаг тутамд шинэчилж байхаар тохиргоог хийж, тогтмол шинэчилж байгаа бөгөөд цахим хуудсанд байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалттай 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар хандалт хийсэн иргэний тоо 45668 байна. Үүнээс **44475** иргэн мэдээллээ алдаагүй зөв гэж баталгаажуулсан бөгөөд **1193** иргэний мэдээлэл зөрүүтэй гэжээ. Мэдээлэл зөрүүтэй иргэдийн мэдээллийг тухай бүр шийдвэрлэж, 7 хоног тутам мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. 2021 оны 5-р сарын 7-ны байдлаар **488** зөрүүтэйг зөрчлийг арилгаж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/215 дугаар тушаалын дагуу иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг 4 дүгээр сарын 10-ны өдрөөс зогсоож, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны “Шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалт хийх удирдамж”-ийн дагуу 1 дүгээр сарын 2-ны өдрөөс иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зогсоох хүртэлх хугацаанд бүртгэгдсэн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 30512 бүртгэлд хяналт тавьж, 597 зөрчлийг илрүүлж, илэрсэн зөрчлийн 86.4 хувийг арилгасан байна. Үүнээс нийслэлд 17785 бүртгэлд хяналт тавьж, 269 зөрчлийг илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу нийслэлийн 457 хэсэгт улсын бүртгэлийн 583 итгэмжлэгдсэн ажилтан ажиллуулахаар саналаа хүргүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/239, А/264 дүгээр тушаалаар шийдвэрлүүлсэн.

Бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 906 иргэдийн материалыг Тагнуулын ерөнхий газарт хүргүүлэн 906 иргэний талаарх саналыг авч 583 иргэнтэй гэрээ байгуулан улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнаар томилон ажиллуулсан.

Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны ажиллах техник, тоног төхөөрөмжид үйлдлийн системийг бэлтгэж, загвар файлыг 4 дүгээр сарын 29-ний өдөр бэлтгэж, 30-ны өдрөөс тоног төхөөрөмжид үйлдлийн системийг хуулах ажлыг эхлүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэгт заасны дагуу Улсын дээд шүүх, Батлан хамгаалахын яам, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар зэрэг төрийн 6 байгууллагатай мэдээлэл солилцох, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/221 дугаар тушаалаар байгуулж, дундын программын эрхийг нээж, мэдээлэл хүлээн авах ажлыг эхлүүлж өөрчлөлтийг мэдээллийн санд тусгасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэг”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах журам”-ын 3.3,3.4,3.5-д заасны дагуу өөрчлөлт оруулсан сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө цахим сангаас 2 хувь хэвлэж, 1 хувийг сонгуулийн хэсгийн хороонд ,1 хувийг улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд олгоно гэсний дагуу хуулийн хугацаанд 457 хэсгийн 1010384 сонгогчийн 928063 үндсэн сонгогч, 82321 түр хасав тэмдэглэгээтэй 39772 хуудас бүхий сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэж, сонгуулийн хэсгийн хороодод хүргэх ажлуудыг зохион байгуулж ажиллаа.

Дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд 2021 оны 5 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд батлагдсан хуваарийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан

эрх зүйн цахим сургалтыг зохион байгуулж, нийслэлийн хэмжээний нийт 457 хэсгийн хороонд ажиллавал зохих 583 итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1,24.2,24.3 дахь хэсэгт заасан дараах этгээд сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих 5-р сарын 25-ны 23.59 цаг минутаар тасалбар болгож дүүрэг дэх бүртгэлийн хэлтэс ажилласан. Нийслэлийн хэмжээнд 2682 сонгогч шилжин ирж, 2753 сонгогч шилжин явсан.

Урьдчилсан байдлаар сонгогчийн нэрсийн жагсаалтыг 2 хувь үйлдэж хэсгийн хороонд шилжүүлэн өгсөн хэвлэлттэй холбоотой принтерийн хор бичгийн цаас бусад бичиг хэргийн материалыг УБЕГ-ын даргын А/176 тоот тушаалын дагуу бэлтгэж холбогдох дүүрэгт хуваарилж, сонгуулийн техник хэрэгсэл хүлээн авах, буцааж татах хуваарь гаргаж нүүлгэлтийн компанитай гэрээ хийж зардлыг шийдвэрлэж тоног төхөөрөмжийг дүүрэг дэх Тагнуулийн Газар, Цагдаагийн хэлтэсээс хамгаалалт авч сургалт болох байранд татан авсан.

Тус газрын дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд 2021 оны 6 дугаар сарын 3-4-ны өдрүүдэд УБЕГ-аас батлагдсан хуваарийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан мэдээллийн технологийн болон эрх зүйн сургалтыг танхимаар зохион байгуулав. Уг сургалтаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлах шалгахтай холбоотой анхаарах асуудлууд, сонгогчийн бүртгэлийн программ хангамж, тоног төхөөрөмжийн хэрхэн ашиглах талаар улсын бүртгэлийн байгууллагын ажилтан нарыг нэгдсэн удирдлагаар хангах ажлыг УБЕГ, ИБГ, МТГ, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд хамтран зохион байгуулж ажиллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтанд өөрчлөлтийг тусгаж хэвлэж сонгуулийн хэсгийн хороодод хүргэх ажлыг амжилттай зохион байгуулсан.

2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг ханган тоног төхөөрөмжүүдийг суурилуулан 2021 оны 6 дугаар сарын 9-ний өдөр сонгуулийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, ямар нэг зөрчил дутагдалгүй ажилласан.

ДӨРӨВ. КОВИД ЦАР ТАХЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

Бүх нийтийн өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлсэн ажил:

Гамшгаас хамгаалах 2021 оны төлөвлөгөө боловсруулан Нийслэлийн онцгой байдлын газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Э.Эрдэнэбаатараар хянуулан, тус газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган, биелэлтийг жилийн эцсээр хүргүүлэн ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/102 дугаар тушаалаар Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам батлагдсан бөгөөд уг журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлж ажиллаж байна.

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Гамшгаас хамгаалах бүртгэл мэдээллийн алба/ нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг ослын үед

орон гэргүй болсон иргэдийг бүртгэх, сураггүй алга болсон иргэдийн мэдээллийг гаргаж удирдлагад танилцуулах, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулж, гамшиг ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан.

Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 391 дугаар албан бичгийн дагуу хөдөлгөөнт төхөөрөмжөөр мэдээллийн сангийн сүлжээг Нийслэлийн онцгой комисст байршуулан Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үед цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор Нийслэлийн онцгой комиссын захиргааны багийн бүрэлдэхүүнд тус газрын Архивын хэлтсийн мэргэжилтэн нар ээлжлэн ажиллаж халдвар тээгчтэй шууд болон дам хавьтсан иргэдийн лавлагаа, мэдээллийг тухай бүр гарган мэдээллээр шуурхай хангаж ажилласан.

Мөн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажилласан тухай мэдээлэл /бүртгэлийн тоо болон Коронавирусын халдвар авч эерэг гарч батлагдсан тохиолдол, одоо эмчлэгдэж байгаа, тусгаарлалтад байгаа, эдгээд гарсан албан хаагчдын тоон мэдээ/-ийг өдөр бүр нэгтгэн гаргаж, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Нийслэлийн онцгой комиссын шуурхай штабт тус тус хүргүүлж ажиллаж байна.

Нийслэлийн Онцгой комиссын 2021 оны 710, 717 дугаар албан бичиг, 2021 оны 18 дугаар хурлын тэмдэглэлд заасны дагуу тус газрын албан хаагчдыг КОВИД-19 нэмэлт тунгийн вакцинд идэвхтэй хамруулж, дархлаажуулалтад хамрагдсан албан хаагчдын мэдээг өдөр бүр Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Нийслэлийн онцгой комиссын Шуурхай штабт цахимаар тус тус хүргүүлж ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах чиглэлээр Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын даргын 2021 оны А/01, А/02 дугаар тушаалыг тус тус гарган хэрэгжилтийг ханган ажиллав.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын даргын 2021 оны А/05 дугаар “Гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн анги байгуулах тухай” тушаал гаргаж, бэлэн байдлыг хангуулсан.

Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын дарга болон дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсийн дарга нар Нийслэл, дүүргийн онцгой комиссын Шуурхай штабт 24 цагийн үүрэг гүйцэтгэж ажилласан. Мөн дарга нар товчоо, постуудаар явж ажилласан.

Тайлангийн хугацаанд Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу нийт албан хаагчдын 5 хүртэлх хувийг ажиллуулах чиглэлийн дагуу тус газар болон дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг 4 удаа батлан хуваарийн дагуу ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/85 дугаар захирамжийн дагуу “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд 2021 оны 2 дугаар сарын 8-ны өдрөөс 10-ны өдрүүдэд **400** албан хаагчдыг PCR шинжилгээнд хамруулсан. Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдөр баталсан “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд нийт **210**

албан хаагч дүүргийн Онцгой комиссын баг, ажлын хэсэгт орж хороодод ажилласан.

Нийтийн хэв журам сахиулах эргүүлд 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын **238** албан хаагч, 2021 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өдөр бүр 87-105 албан хаагч, нийт 293 албан хаагч 2 ээлжээр эргүүлээр ажиллаж, давхардсан тоогоор 1305 удаа эргүүл жижүүр хийсэн байна.

Тайлангийн хугацаанд Ковид-19 цар тахалтай холбоотой нийт 25 төрлийн санал, судалгаа, тайлан, илтгэх хуудсыг боловсруулж, холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлэв.

Хөл хорионы онцгой нөхцөл байдалтай холбоотойгоор Улс, Нийслэлийн онцгой комиссоос гарч байгаа шийдвэр, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийг танилцуулах, үүрэг чиглэл өгөх зорилгоор газрын шуурхай хурлыг 22 удаа, хэлтсүүд албан хаагчидтайгаа тухай бүр цахим хурал зохион байгуулж шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажилласан.

Эрүүл мэндийн яам, Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэр, удирдамжийг биелүүлэх хүрээнд Улс, Нийслэлийн онцгой комисс, Эрүүл мэндийн яамны /www.mohs.mn/ цахим хуудас, эрүүл мэндийн байгууллагуудын зөвлөмж, шийдвэрийг тухай бүр газрын цахим хуудсанд байршуулан иргэд, албан хаагчдыг мэдээллээр шуурхай ханган ажиллаж байна.

Ариутгал, халдваргүйжүүлэлтийн чиглэлээр: Коронавируст /Ковид-19/ халдвараас өвчнөөс урьдчилан сэргийлж байгууллагын үүдний хэсэгт автоматаар биеийн дулаан хэмжих болон халдваргүйтгэл хийх төхөөрөмж байрлуулан үйлчлүүлж буй иргэд болон байгууллагын албан хаагчдын биеийн халууныг тогтмол хэмжиж, байгууллагын QR кодыг уншуулан нэвтрүүлж байна.

Албан хаагчдыг халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд урьдчилан сэргийлэлт, ариутгал, халдваргүйжүүлэлтэд шаардагдах зардлыг байгууллагын төсвөөс гаргаж, урьдчилан сэргийлэлт, ариутгал, халдваргүйжүүлэлтэд зориулан тус газраас дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүдийг гар ариутгагч бодис 463ш, санитол /5л/ 14ш, маск 14840, маск /KF95/ 5600ш, шилэн маск 32, гар ариутгагч бодис 463ш, нэг удаагийн малгай 5720ш, нүүрний хаалт 2300, нэг удаагийн бээлий 77 хайрцаг 2900ш, солонгос бээлий 1490ш, халад 764ш, агааржуулах уусмал 7ш, ариутгалын бодис 3 хайрцаг, 160 метр гялгар хаалтаар тус тус хангаж, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.


Мөн БНСУ-ын Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд 9 дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсүүдийг техник, тоног төхөөрөмж болон коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын хэрэгсэл /ариутгалын хаалга 1ш, ариутгалын шүршигч машин 11ш, тасалгаа цэвэрлэгч багц 11ш, агаар ариутгагч 20ш, халуун хэмжигч дэлгэц 8ш, малгай 331ш, маск /№95/ 23000ш, гар ариутгагч бодис 3080ш, нэг удаагийн бээлий 325 хайрцаг/-ээр хангасан.

Тус газрын ажилтан, албан хаагчид нь гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Улс, нийслэл, дүүргийн онцгой комисс, мэргэжлийн байгууллагуудын шийдвэр, зөвлөмж, аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлэн, нийслэл, дүүргийн Онцгой комисс, хууль

хяналтын болон холбогдох байгууллагуудыг мэдээллээр шуурхай хангаж ажилласан.


ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ

5.1 Монголчуудын оюуны үнэт өв болсон үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлж, олон нийтэд сурталчилах, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, монгол бичгээ сэргээн хэрэглэх төрийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор “БИД МОНГОЛ БИЧИГТЭН ХАМТ ОЛОН” аяныг 2021 оны 5 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл зохион байгуулах удирдамжийг батлан ажилласан. Уг аяны хүрээнд албан хаагчдаас монгол бичгийн түвшин тогтоох сорил авч монгол бичгийн анхан шатны мэдлэггүй албан хаагчдын судалгааг гарган тусгай төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулж, шалгалт авч үр дүнг тооцох арга хэмжээг авч ажилласан. Тус газраас Монгол бичгийн түвшин тогтоох судалгаанд 415 албан хаагчдыг хамруулж, цуврал сургалтыг эхлүүлэн албан хаагчдын түвшинг ахиулан ажилласан. Уг аяны хүрээнд “Сайхан бичигтэн” шалгаруулах бичвэрийг 2021 оны 11 дүгээр сарын 10-13-ны хооронд зохион байгуулж 1,2,3 дугаар байр эзлүүлэн шагнаж урамшуулсан. Мөн аяныг хамгийн сайн зохион байгуулж албан хаагчдыг бүрэн хамруулсан 1 хэлтсийг шалгаруулан ажилласан.



Улсын бүртгэлийн ерөнхий газраас бэлтгэн хүргэж байгаа монгол бичгийн цахим хичээлийг бие даан судлахыг нийт албан хаагчдад үүрэг болгосон, газрын фейсбүүк групп дээр хуваалцаж байна.


5.2 Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус газрын нийт ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн дунд “МИНИЙ ААВ, ЭЭЖИЙН АЖИЛ-МИНИЙ БАХАРХАЛ” сэдэвт гар зургийн уралдааныг 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 28-ныг хүртэл зохион байгуулж ажилласан. Уг тэмцээнийг тус газрын нийт албан хаагчдын хүүхэд, багачуудын авъяас чадварыг нээн хөгжүүлэх, эцэг, эхийн эрхэлдэг ажлын талаар тодорхой ойлголт, мэдлэг олгох, хүүхдийн өөрийн үзэл бодлоо чөлөөтэй, бүтээлч байдлаар илэрхийлэхийг дэмжих, байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор зохион байгуулсан бөгөөд уралдаанд ирүүлсэн зургуудаар үзэсгэлэн гаргаж, оролцсон хүүхдүүдийг шагнаж урамшуулав.



5.3 Жендерийн үндэсний хорооноос “Монгол цэргийн өдөр буюу 3 дугаар сарын 18-ны өдрийг тохиолдуулан “Би жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг” аяныг өрнүүлсэн.



5.4 Багануур дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс албан хаагчдыг ая тухтай ажиллах нөхцөлийг бий болгох зорилгоор өөрсдийн хөрөнгөөр 5 дугаар хорооны улсын бүртгэгчийн албан өрөөг засварлан ажиллалаа.



5.5 Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж “Нэг цонхны үйлчилгээний танхим”-д 25 сая төгрөгийн засвар тохижилтын ажлыг хийж, ширээ сандалыг шинэчилсэн.



5.6 Чингэлтэй дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэс 2021 оны 1 дүгээр сард тус дүүргийн тамгын газарт байрлах 1 давхарын өөрсдийн сууж буй өрөөг өөрсдийн нөөц бололцоогоор засвар үйлчилгээ хийж, Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны улсын бүртгэгчийн өрөөнд “Ёслолтой бүртгэл” хийх булан тохижууллаа.



ЗУРГАА. САЙН ҮЙЛСИЙН ХҮРЭЭНД:

6.1 Нийслэлийн Засаг даргаас Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, дүүргийн харъяа хэлтэс албад, хороод “Дэм дэмэндээ” аяныг зохион байгуулж, айл өрхүүдэд хүнсний тусламж үзүүлэх ажлыг яаралтай зохион байгуулах чиглэл өгсний дагуу дараах арга хэмжээг авч ажиллалаа.

Нийслэл дэх улсын бүртгэлийн газрын хэмжээнд “Дэм дэмэндээ” аяны хүрээнд тайлангийн хугацаанд амьжиргааны түвшин доогуур, бага орлоготой 125 өрхөд хүнсний багц, 166 албан хаагчид хүнсний болон амин дэмийн багцыг тус тус хүргүүлэн ажилласан байна.



6.2 Нийгмийн хариуцлагын хүрээнд, COVID19 цар тахал дэгдсэнтэй холбогдуулан дүүргийн Цагдаагийн постонд ээлжинд гарч буй Онцгой, Цагдаа, Хүн эмнэлгийн албан хаагчдад халуун хоол, цайгаар үйлчиллээ.


6.3 Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг угтсан сарын ажлын төлөвлөөгөөний дагуу Чингэлтэй дүүргийн ГБХЗХХ-ийн дэргэдэх "Хүүхэд хамгаалах байр"-нд байрлаж буй хүүхдүүдэд эд зүйлсийн тусламж үзүүлэн, тухайн байгууллагын хананд зураг зурж өгсөн.



6.4 Хан-Уул дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс **“САЙН ҮЙЛСИЙН АЯН”** 4-8 дугаар хорооны нэн ядуу эмзэг бүлэгт хамаарах энэ жил 1-р ангид орж байгаа зорилтот бүлгийн 12 хүүхдэд цүнх, хичээлийн хэрэгсэл бэлэг болгон өглөө.



6.5 Номын баярын өдрийг тохиолдуулан “Номоор дэмжье, оюунаар дэмнээ” аяны хүрээнд нийт 48 ширхэг ном цуглуулан дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст хүлээлгэн өглөө.



6.6 Сүхбаатар дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсээс олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хэлтсийн бүх албан хаагчдын хүүхдүүдэд “zolo dent” шүдний эмнэлэгтэй шүдээ хөнгөлөлттэй үнээр эмчлүүлэх эрхийн бичиг гардуулан өглөө.



6.7 “Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөө” аянд бүртгэлийн хэлтсийн хамт олон нэгдлээ. Уг арга хэмжээний хүрээнд өөрт хэрэглэхгүй хувцас эд зүйлс гутал гэх мэт зүйлсийг авч ирж, хэрэгтэй хүмүүст хандивлаж, өөрт хэрэгтэй зүйлээр солилцож оролцлоо.

Уг аяны хүрээнд цугласан хувцас гутал, ном сэтгүүл эд зүйлсийг ангилан ялгалт хийж, угааж цэвэрлэн, ариутгал халдваржуулалтыг хийсэн.

Арга хэмжээнд цугларсан эд зүйлсийг Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны ажлын албанд хүлээлгэн өгсөн.



Газар, хэлтсийн албан хаагчид Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон дүүргүүдийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Хоггүй дүүрэг болоё”, “Мод тарья”, “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, хаврын их цэвэрлэгээ, тохижилтын арга хэмжээнүүдэд бүрэн хамрагдсан байна.



ДОЛОО. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР:

1. Хууль хяналтын болон төрийн бусад байгууллагатай хуулийн хүрээнд ажлаа идэвхтэй уялдуулан хамтарч ажиллах;
2. Иргэд, хуулийн этгээдэд үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах;
3. Хороодоос ялангуяа алслагдсан хороодоос улсын бүртгэлийн үйлчилгээ авахад үйлчилгээний төлбөр хураамжийн асуудал хүндрэл учруулж байна. Иймээс бүх хороодод цахим төлбөрийн машин байршуулах, эсвэл интернет банкаар төлбөр авах асуудлыг нэгдсэн журмаар шийдвэрлэх;
4. Анхан шатны нэгжээс үзүүлэх бүртгэлийн тоог нэмэгдүүлэх;

НАЙМ. САНАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

1. Нийслэл дэх улсын бүртгэлийн байгууллага улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үзүүлдэг. Нийслэл дэх улсын бүртгэлийн газар нь түрээсийн байранд, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтсүүд харъяа дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд байрлаж үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хүн ам, барилга байгууламж жил бүр өсөн нэмэгдэхийн хирээр ажлын байр, архивын сан хөмрөгийн багтаамж хүрэлцэхгүй байдал үүсч байна. Архивын сан хөмрөгт нийслэлийн 1450000 гаруй иргэдийн хувийн хэрэг материал хадгалагдаж байгаа бөгөөд архивын сан хөмрөг багтаамжгүй болсон байна.

Нийслэлийн хэмжээнд бүртгэлийн архив 10 нэгжид байршиж байгаа бөгөөд зориулалтын бус хонгилын давхар, автомашины гражид байгаа нь архивын баримт хадгалах орчны стандарт шаардлагыг хангаж чадахгүй, улсын бүртгэлийн эх нотлох баримт бүхий архив үрэгдэх, устах өндөр эрсдэлтэй байна.

Иймд тус газар, хэлтсүүдэд ажлын байрны асуудлыг шийдвэрлэх, нягтруулсан шүүгээгээр хангах.

2. Иргэд, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ил тод хүргэхэд зайлшгүй хийгдэх шинэчлэл нь төрийн үйлчилгээг цахимжуулах, онлайн хэлбэрт шилжүүлэх явдал юм.

Иймд онлайн болоогүй байгаа үйлчилгээнүүдийг үе шаттайгаар онлайн болгох.

3. Анхан шатны нэгжээс үзүүлж буй бүртгэлийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагааны эрх олгох;

4. Иргэний улсын бүртгэгчийн хариуцлагыг өндөржүүлж хийсэн бүртгэлийг баталгаажуулах эрхийг олгох;

НИЙСЛЭЛ ДЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР